

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ АВТО ЗАМЫН БОДЛОГО  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД 2025 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ  
ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2026.01.09

**Нэг. Зорилго, арга зүй**

ЗТЯ-ны АЗБЗГ-ын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт болон үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, мөн оны 183 дугаар тогтоолоор баталсан “Хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн биелэлтэд хяналт тавих нийтлэг журам”, 2022 оны 352 дугаар тогтоолоор баталсан “Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам”, Зам, тээврийн сайдын 2025 оны А/310 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлж дүгнэх журам”-ыг тус тус үндэслэл болгосон.

**Хоёр. Танилцуулга**

АЗБЗГ-ын үйл ажиллагааг 2025 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайд, ТНБД-ын тушаалын хэрэгжилт, Зам, тээврийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилт гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 77.4%-тай үнэлэгдлээ. Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

**2.1. МУ-ын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт:**

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	
32	10	7	12	3	62.7%

**2.2. МУ-ын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт:**

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин				Хэрэгжилтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”	
38	16	2	18	2	65.1%

**2.3. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт:**

Нийт	Үүнээс				Хэрэгжилтийн хувь
	100%	Хэрэгжих шатанд	0%	Хугацаа болоогүй	
89	43	43	3	-	76.0%

**2.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт:**

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хэрэгжих боломжгүй	
99	63	18	1	15	2	87.8%

**2.5. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:**

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
54	44	6	2	2	0	90.38%

**2.6. ТНБД-ын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:**

Нийт заалт	Үүнээс					Хэрэгжилтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
104	93	6	4	1	-	93.2%

**2.7. Аймаг, Нийслэлийн Засаг дарга нартай байгуулсан гэрээ, “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт:**

Аймаг, нийслэл	Арга хэмжээ	Үүнээс:				Хэрэгжилтийн хувь
		Хэрэгжсэн	Хэрэгжих шатанд	Хэрэгжээгүй	Хэрэгжих боломжгүй	
		100%	50%	0%		
Нийслэл	10	1	9	-	-	61%
Архангай	5	2	3	-	-	70%
Баян-Өлгий	4	4	-	-	-	100%
Баянхонгор	5	4	-	-	1	100%
Булган	5	2	3	-	-	70%
Говь-Алтай	4	2	2	-	-	75%
Говьсүмбэр	4	4	-	-	-	100%
Дархан-Уул	5	4	1	-	-	90%
Дорноговь	5	3	1	-	1	87.5%
Дорнод	5	4	1	-	-	90%
Дундговь	4	3	1	-	-	87.5%
Завхан	5	1	4	-	-	60%
Орхон	4	3	-	1	-	75%
Өвөрхангай	5	4	-	-	1	100%
Өмнөговь	4	3	1	-	-	87.5%
Сүхбаатар	5	4	1	-	-	90%
Сэлэнгэ	5	5	-	-	-	100%
Төв	5	4	1	-	-	90%
Увс	5	3	2	-	-	80%
Ховд	5	3	2	-	-	80%
Хөвсгөл	4	3	1	-	-	87.5%
Хэнтий	4	3	-	1	-	75%
<b>Нийт</b>	<b>107</b>					<b>84.4%</b>

Гурав. Үнэлэлт, дүгнэлт

Төлөвлөлтийн байдал:

Монгол Улсын төсвийн тухай хуульд тусгуулахаар санал хүргүүлсэн боловч хасагдсан, санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад санал хүргүүлсэн, тендер зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй, ТЭЗҮ, зураг төслийн шатанд байгаа, санхүүжилт шийдвэрлэгдээгүй, зам барилгын ажил эхлээгүй төсөл, арга хэмжээний “шалгуур үзүүлэлт”-ийг “барилгын ажлын гүйцэтгэл”-ийн хувиар тооцохоор батлуулсан нь тухайн бодлогын бичиг баримтын хэрэгжилт хангалтгүй үнэлэгдэхэд нөлөөлсөн.

Бодлогын баримт бичгүүд болон гүйцэтгэлийн төлөвлөгөөг уялдуулаагүй, төсөл, арга хэмжээний 2025 онд хүрэх түвшинг “зөрүү”-тэй батлуулсан байна. Тухайлбал: Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 664, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 1.5.2.3, Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.2.3-т туссан “Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам”-ын төслийн төлөвлөлтийн байдлыг харвал:

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин (2023)	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)				Хэрэгжүүлэх байгууллага	
						2025	2026	2027	2028	Үндсэн	Хамтран
						Зорилтот түвшин	Зорилтот түвшин	Зорилтот түвшин	Зорилтот түвшин		
664	Дорнод аймгийн Чойбалсан хотыг Хавиргын боомттой холбох 124.5 км хатуу хучилттай авто зам барих	2025-2028	Улсын болон орон нутгийн төсөв	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	24.5	50	70	100	-	Зам, тээврийн яам	Эдийн засаг, хөгжлийн яам

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

ТЕЗ-ийн үр дүн	Хөтөлбөрийн үр дүн	Бодлогын үндэслэл	Төсөл, арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт		Санхүүжилт		Үндсэн хариуцагч
						Суурь түвшин /2023 он/	Зорилтот түвшин /2025 он/	Санхүүжилт, сая.төг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал	
		МУХТЖУЧ-8.1.2, ЗГУАХ-3.3.2.22	1.5.2.3. Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн 124.5 км хатуу хучилттай авто зам барих	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	30	55	48,532.5	Улсын төсөв	Зам, тээврийн яам

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ АВТО ЗАМЫН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

№	Д/Д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв, эх үүсвэр /сая төг/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин, /2024 он/	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
6	1.2.3	Дорнод аймгийн Хэрлэн сумаас Хавиргын боомт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 124.5 км /Дорнод/	2022 -2027 он 185,514.9 2025 он 48,532.5	Барилгын ажлын гүйцэтгэл, хувь	Барилгын ажлын гүйцэтгэл хувь 30	хувьд хүргэнэ.  I улирал: 2024 оны гэрээ дүгнэсэн акт, хурлын тэмдэглэл албажуулна. 2025 оны барилгын ажил гүйцэтгэх график төлөвлөгөөг хянаж, батлуулна. II улирал: Барилгын ажлын гүйцэтгэлийг 32 хувьд хүргэнэ. III улирал: Барилгын ажлын гүйцэтгэлийг 35 хувьд хүргэнэ. IV улирал: Барилгын ажлын гүйцэтгэлийг 40 хувьд хүргэнэ.]	Багц 1: 31 км. Гүйцэтгэгч: "ЗБИБ" ХХК болон "ЗББ" ХХК түншлэл; Зөвлөх: "ЗТХТ" ТӨҮГ; Барилгын ажлын гүйцэтгэл: 45.0%  Багц 2: 32.5 км. Гүйцэтгэгч: "Анандын зам" ХХК; Зөвлөх: "ЗТХТ" ТӨҮГ; Барилгын ажлын гүйцэтгэл: 57.0%  Багц 3: 30 км. Гүйцэтгэгч: "Рүн Хэ Жйу Жөу Констракшн Инженеринг" ХХК; Зөвлөх: "ЗТХТ" ТӨҮГ; Барилгын ажлын гүйцэтгэл: 33.0%  Багц 4: 31 км. Гүйцэтгэгч: "Их монгол барилга" ХХК; Зөвлөх: "ЗТХТ" ТӨҮГ; Барилгын ажлын гүйцэтгэл: 47.6%  Нийт: Барилгын ажлын гүйцэтгэл: 45.7%	100%

Мөн багц ажлуудыг нэгтгэн дундаж үзүүлэлтээр хүрэх түвшинг төлөвлөсөн нь багц тус бүрийн гүйцэтгэлд үнэлгээ хийх боломжгүй нөхцөл үүсэж, улмаар тухайн төсөл хэрэгжих зорилгод хугацаанд хүрэх түвшин хангагдахгүй байх эрсдэлтэй.

**Хэрэгжилтийн байдал:**

1/ АЗБЗГ-ын үйл ажиллагааг 2025 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилт, Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайд, ТНБД-ын тушаалын хэрэгжилт, Зам, тээврийн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний хэрэгжилт гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 77.4%-тай байна.

Эдгээрээс Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хамгийн бага буюу 62.7%-тай, Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 65.1%-тай үнэлэгдсэн байна.

2/ Хангалтгүй үнэлгээтэй төсөл арга хэмжээний хэрэгжилт удааширалтай байгаа нөхцөл, шалтгааныг агуулгаар нь авч үзвэл:

➤ *Гүйцэтгэгч байгууллагын хүн хүч, машин механизмын хүрэлцээ, хуваарилалт зэрэг ажлын зохион байгуулалттай холбоотой төсөл арга хэмжээ:*

- Баруун-Урт-Бичигт чиглэлийн хатуу хучилттай авто зам.

➤ *Түгээмэл тархацтай ашигт малтмал болон газрын зөвшөөрөлтэй холбоотой төсөл арга хэмжээ:*

- Ухаахудаг-Барууннаран чиглэлийн 32 км замын төгсгөлөөс Цагаандэл уул боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто зам;

- Өгийнуур - Мянганы замын хэвтээ тэнхлэг чиглэлийн 28.5 км хатуу хучилттай авто зам;

- Улиастай - Алтай чиглэлийн 40 км хатуу хучилттай авто зам.

➤ *Зураг төслийг шинэчлэн боловсруулж байгаа болон магадлалтай холбоотой төсөл арга хэмжээ:*

- Улиастай-Алтай чиглэлийн 60 км хатуу хучилттай авто зам;

- Ховд-Улаангом чиглэлийн 163 км хатуу хучилттай авто зам;

- Улаанбаатар-Өндөрхаан чиглэлийн 68 км авто замын их засварын ажил;

- Арвайхээр-Баянхонгор чиглэлийн 35 км авто замын их засварын ажил;

- Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 50 км авто замын их засварын ажил;

- Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн 105 км авто замын ээлжит болон их засварын ажил;

- Хархорин-Цэцэрлэг чиглэлийн 40 км авто замын ээлжит болон их засварын ажил;

- Цэцэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн 50 км авто замын ээлжит болон их засварын ажил;

- Багануур-Мөнгөнморьт чиглэлийн хатуу хучилттай авто зам, 60 км.

➤ *Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн баримт бичгийг боловсруулж байгаа, тендер зарласан, тендер хүчингүй болсон, тендер зарласан боловч шаардлага хангасан тендер ирээгүй гэх мэт тендертэй холбоотой болон Улсын төсвийн 2025 оны тодотголоор хасагдсан төсөл арга хэмжээ:*

- Хараа голын 101.08 у/м төмөрбетон гүүр;

- Онги голын 166.7 у/м төмөрбетон гүүрийн их засвар, шинэчлэлтийн ажил;

- Булган – Мөрөн чиглэлийн 13 км авто замын ээлжит болон их засварын ажил;

- Олон улсын чанартай АН-3 ангиллын Улаанбаатар-Дархан-Алтанбулаг чиглэлийн авто замын авто замын нөхцөл байдлыг тодорхойлох хяналтын камер болон тээврийн хэрэгслийн даац хэмжих пүү суурилуулах ажил;

- Хэрээтийн давааны хэсгийн 35.5 км хайрган хучилттай авто зам, Түнэл сумаас Чандмань-Өндөр сум чиглэлийн авто замын Бийжийн даваа, Бор бургасын давааны хэсгийн 9 км хайрган хучилттай авто зам;

- Өвөрхангай аймгийн Есөнзүйл сум хүртэлх 16 км авто зам.

➤ *Хөрөнгө оруулагчийн зүгээс санхүүжилтийн асуудлаа шийдвэрлээгүй буюу санхүүжилттэй холбоотой төсөл арга хэмжээ:*

- Орхон-Хишиг-Өндөр-Гурванбулаг сум чиглэлийн хатуу хучилттай авто замын үргэлжлэл, 31.08 км;

- Дорнод аймгийн Баянтүмэн сумын “Хашаатын цав” нүүрсний уурхайгаас Хавиргын боомт хүртэлх 96.4 км авто зам;

- Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын “Эрээн толгой” нүүрсний уурхайгаас Бичигтийн боомт хүртэлх 101.3 км авто зам;

- Төр, хувийн хэвшлийн түншлэлээр буюу концессын “барих-шилжүүлэх” гэрээгээр хэрэгжиж буй “Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн-Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто зам төслийг үргэлжлүүлнэ.

3/ 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан 89 арга хэмжээний хэрэгжилт 76.0% байна. Үүнээс 96.6% нь хүрэх түвшиндээ хүрсэн болон хүрэх шатандаа, 3.4% нь төлөвлөсөн үр дүндээ хүрээгүй байна.

4/ Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт тус бүрийг хэрэгжүүлэх арга хэмжээний тоо, хэрэгжилтийн хувиар харуулбал:

Зорилт	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь	
Зорилт 1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2738.95 км /шилжих 1578.51 км, шинэ 1160.44 км авто зам, 1800.53 у/м /шилжих 878.93 у/м, шинэ 921.6 у/м гүүрийн нийт 50 төслийг хэрэгжүүлж, үүнээс шинээр 15 төслийн барилгын ажлыг эхлүүлнэ.	1.1 Олон улсын авто замын шинэ коридор байгуулах, аймгийн төвүүдийг хатуу хучилттай авто замаар холбох төслүүдийг үргэлжлүүлнэ.	3	100
	1.2. Хилийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбох төслүүдийг үргэлжлүүлнэ.	5	84.4
	1.3. Мянганы замын хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлнэ.	2	72.5
	1.4. Аялал жуулчлал, бүс орон нутгийн хөгжлийг дэмжих төслүүдийг үргэлжлүүлнэ.	22	83.0
	1.5. Нутгийн зам төслийн хүрээнд 11 сумыг хатуу хучилттай авто замаар холбох барилгын ажлыг үргэлжлүүлж, 5 сумыг хатуу хучилттай авто замаар холбоно.	10	91.0
	1.6. Орон нутагт 4 байршилд 854.93 у/м төмөр бетон гүүрийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ.	4	100
Зорилт 2. Гадаад зээлийн санхүүжилтээр 203 км авто замын барилгын ажлыг хэрэгжүүлж, 361 км авто зам, 1205 у/м гүүрийн их засварыг эхлүүлнэ.	2.1. Олон улсын авто замын шинэ коридор байгуулах, аймгийн төвүүдийг хатуу хучилттай авто замаар холбох төслүүдийг үргэлжлүүлнэ.	10	63.6
	2.2. "Монгол Улсын тээврийн холболт ба логистикийг сайжруулах төсөл"-ийн хүрээнд улсын чанартай авто зам болон төмөр бетон гүүрийн ээлжит болон их засварын ажлыг эхлүүлнэ.	8	26.3
	2.3. ЗГҮАХ-т гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тусгагдсан авто замын ажлуудын санхүүжилтийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авна.	5	94.0
Зорилт 3. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нийт 6 төслийн 1347.7 км /шилжих 447.7 км, шинэ 900 км/ авто зам барилгын ажлыг хэрэгжүүлнэ.	3.1. Хилийн 3 боомтыг тусгай зориулалтын хатуу хучилттай авто замаар холбох ажлыг үргэлжлүүлнэ.	3	53.3
	3.2. Хилийн 4 боомтыг тусгай зориулалтын хатуу хучилттай авто замаар холбох барилгын ажлыг эхлүүлнэ.	4	77.5
	3.3. Төр хувийн хэвшлийн түншлэл хүрээнд аймгийн төв холбох авто замуудыг барина.	2	50.0



Зорилт 4. Олон улс, улсын чанартай 14,891.4 км авто замын бэлэн байдлыг хангуулж, нийт 3 чиглэлийн 183 км замын их засвар шинэчлэлтийн ажлыг эхлүүлж, 4 төслийн 618.35 км авто замын зураг төслийг боловсруулна.	7	77.1
Зорилт 5. Авто замын салбарын эрх зүйн орчин, стандарт, норм шинэчлэн сайжруулж, боловсронгуй болгоно.	4	76.0
<b>НИЙТ</b>	<b>89</b>	<b>75.6</b>

5/ *Зорилтот түвшин:* Нийт 4289.65 км /шилжих 2229.21 км, шинэ 2060.44 км/ авто зам, 1800.53 у/м /шилжих 878.93 у/м, шинэ 921.6 у/м/ гүүрийн ажил хэрэгжүүлж нийт 588.13 км хатуу хучилттай авто замыг байнгын ашиглалтад оруулна. 16 аймгийн 12 сум, 3 хилийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбох ажлыг хэрэгжүүлнэ.

*Хүрсэн түвшин:* Нийт 4289.65 км /шилжих 2229.21 км, шинэ 2060.44 км/ авто зам, 1800.53 у/м /шилжих 878.93 у/м, шинэ 921.6 у/м/ гүүрийн ажил хэрэгжүүлж нийт 280.7 км хатуу хучилттай авто замын ажлыг байнгын ашиглалтад оруулсан. 16 аймгийн 12 сум, 3 хилийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбох ажлыг хэрэгжүүлсэн.

Нийт 588.13 км хатуу хучилттай авто замыг байнгын ашиглалтад оруулна гэж төлөвлөснөөс 280.7 км хатуу хучилттай авто замын ажлыг байнгын ашиглалтад оруулсан байна.

### **Дөрөв. Санал, зөвлөмж**

Авто замын бодлого, зохицуулалтын газрын хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2025 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-нд туссан төсөл, арга хэмжээг газрын болон албан хаагчдын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бүрэн тусгах;
2. Төсөл арга хэмжээний суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөх;
3. Авто замын барилгын ажлын гүйцэтгэлийн мэдээг төсөл арга хэмжээ тус бүрээр гаргаж, нэгтгэн улирал тутам тогтоосон хугацаанд Салбарын хяналт-шинжилгээ, дотоод аудитын газарт дотоод бичгээр ирүүлж байх;
4. Цаашид биелэлтийн тайлан ирүүлэхдээ биелэлтэд тавигдах шаардлагуудыг мөрдөж биелэлтийг алдаагүй, тоо баримттай, үнэн зөв тайлагнаж, хянан баталгаажуулах;
5. Төсөл, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрэхгүй байх эрсдэлийг урьдчилан тооцоолж, хариу арга хэмжээг шуурхай авч ажиллахыг тус тус зөвлөж байна.

**САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

**ЗТЯ-НЫ ГАЗРЫН АВТО ЗАМЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭНИЙ НЭГДСЭН ДҮН**

№	Үзүүлэлт		Төсөл, арга хэмжээний тоо	Хэрэгжи лтийн хувь	Жин- лэсэн хувь
1	Бодлогын үр дүн	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	32	62.7	20
2		Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт	38	65.1	20
3	Чиг үүргийн үзүүлэлтийн дүн (үнэлгээ)	Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт	89	76.0	20
4		Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	99	87.8	20
5		Сайдын тушаалын хэрэгжилт	54	90.4	10
6		Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт	104	93.2	10
7	Чадамжийн үнэлгээ	Зам, тээврийн сайдын аймаг, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээ, “Санамж бичиг”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилт	107	84.4	10
<b>Нийт</b>			<b>523</b>	<b>77.4%</b>	

---oOo---